



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/211

Мандалговь

Дундговь- Ус ОНӨҮГ-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Дундговь- Ус ОНӨҮГ”-тай 199,999,763 (нэг зуун ерэн есөн сая есөн зуун ерэн есөн мянга долоон зуун жаран гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах ажил”-ыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дундговь- Ус ОНӨҮГ”-ын дарга (О.Бархүү)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4823150505